



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/191

Хэрлэн сум

Автотээврийн хэрэгслийн бүртгэл
тооллогыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.10, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1.1, 7.1.3, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай” А/57/48 хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2023 оны 4 дүгээр сарын 30-ыг дуустал, “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ”-г суурилуулах ажлыг 2023 оны 12 дугаар сарын 31-ийг дуустал зохион байгуулсугай.

2.Авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллого, “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ”-г суурилуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээний ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл тооллогод бүрэн хамруулах, “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ”-г суурилуулах ажлын хэсэг орон нутагт ажиллах нөхцөлийг боломжоор хангах, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрт гарган өгч, хамтран зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл тооллого, “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ”-г суурилуулах ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулан, тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ), гишүүдэд даалгасугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 28-ны өдрийн
А/101 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ТООЛЛОГО,
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭ
ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга	Э.Мөнх Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Авто тээврийн төвийн дарга
Гишүүд:	А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
	Д.Батхүү	Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа
	Г.Эрийнтовч	Авто тээврийн төвийн бүртгэлийн мэргэжилтэн
	Б.Баярмагнай	Авто тээврийн төвийн Техник хяналтын үзлэгийн инженер
	Сумын Засаг дарга нар	



Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 28-ны өдрийн
А/191 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/57/48 хамтарсан тушаалыг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Хугацаа

Авто тээврийн хэрэгсэлийн шинэчилсэн бүртгэл тооллого зохион байгуулах ажлыг 2023 оны 3 дугаар сарын 27-ний өдрөөс эхлэн 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал, “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ”-г суурилуулах ажлыг зохион байгуулах ажлыг жилийн турш

Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага:

- Хэнтий аймгийн Авто тээврийн төв

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд:

- Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар
- Хэнтий аймгийн Татварын хэлтэс
- Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар
- Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар
- Сумдын Засаг даргын Тамгын газар

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Ажлын алба	Хийх ажлын хуваарь	Хариуцах эзэн
1	Аймгийн Автотээврийн төв	1. Тээврийн хэрэгслийн судалгааг сум, багаар гарган хамтран ажиллах байгууллагуудад хүргүүлэх. 2. Тооллогод хамрагдсан талаарх мэдээллийг сумдаас авч нэгтгэх. 3. Аймгийн хэмжээний нэгдсэн бүртгэлтэй уяалдуулан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ”-(PFID tag)-г тээврийн хэрэгслийд олгох арга хэмжээг мэргэжил арга зүйгээр ханган зохион байгуулах 4. Ажлын хэсгийн гишүүдэд (онлайн болон биечлэн ажлын төлөвлөгөөг танилцуулах)	Ц.Бат-Эрдэнэ Автотээврийн төвийн дарга
2	Аймгийн татварын хэлтэс Сумын ЗДТГ Багийн дарга нар	1.Сумын засаг даргын захирамжаар комисс томилж ажил зохион байгуулах Үүнд: -Сумын комисст татварын байцаагч, багийн Засаг дарга нар, цагдаагийн ажилтан зэрэг үүрэг бүхий бусад хүмүүсийг оролцуулна. Аян зохион байгуулагдахаас өмнө тээврийн хэрэгсэл нь зарсан боловч албан ёсны шилжүүлэг хийлгээгүй, цаашид ашиглах боломжгүй болсон боловч албан ёсны хасалт хийлгээгүй, олон жилийн хуримтлагдсан өртэй тээврийн хэрэгсэл эзэмшигчидтэй биечлэн болон утсаар холбогдож, өрийн мэдээлэл, төлөх боломжуудыг танилцуулан тэмдэглэл хөтлөнө. Мэдээлэл хүргэн ажилласан татвар төлөгчдийн өрийг бүрэн барагдуулан холбогдох төсөвт төвлөрүүлэн, “Татварын өргүй” гэсэн тодорхойлолтыг тээврийн хэрэгсэл бүрээр гаргаж өгөх.	А.Гантөмөр - Татварын хэлтсийн дарга Сумын Засаг дарга, Багийн дарга нар

		<p>2. Аяны хүрээнд нийт тээврийн хэрэгсэлтэй эзэмшигчидтэй холбогдсон байх</p> <p>3. Мөн төсөвт байгууллагуудын тээврийн хэрэгслийн бүртгэл тооллогын мэдээллийг шинэчлэн, ОНӨГ-ийн бүртгэлийг АТТ-ийн бүртгэлтэй тулгаж, зөрүүг арилгах, татварын өртэй бол бүрэн төлж барагдуулах</p> <p>4. Нийт тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг сум, багуудаар нь хуваарь гарган багийн Засаг дарга нарт хариуцуулж тооллот заавал хамруулсан байх</p> <p>5. Багийн засаг дарга нар нутаг дэвсгэртээ байгаа хасагдах тээврийн хэрэгслийн бүртгэлийг шинэчлэн гаргаж, бүртгэлээс хасах тээврийн хэрэгслийн холбогдох материалыг бүрдүүлж хасуулахад бэлэн болгох</p> <p>6. Сумын удирдлага тооллогын үйл явцад хяналт тавьж дүнг нэгтгэн гаргаж комисст хүргүүлнэ.</p> <p>7. Аймгийн хэмжээний нэгдсэн бүртгэлтэй уяалдуулан “ Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахимм гэрчилгээ”-(RFID tag)-г тээврийн хэрэгслийд олгох арга хэмжээг хамтран зохион байгуулах,</p>	
3	Цагдаагийн газар, Сумд дахь Цагдаагийн тасгийн дарга, Байцаагч, төлөөлөгч нар	<p>1. Гэмт хэрэг зөрчилд холбогдсон, журамлагдсан, саатуулагдсан тээврийн хэрэгслүүдийг тооллогод хамруулахад анхаарч ажиллах</p> <p>2. ЗГ-ын 2002 оны 47 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу тээврийн хэрэгслийн ТХҮзлэгт ороогүй, АТБӨЯХ-ийн албан татвар, агаарын бохирдлыг төлбөрөө төлөөгүй тохиолдолд автозамын хөдөлгөөнд оролцохыг хориглох ,</p> <p>3. Аймгийн хэмжээний нэгдсэн бүртгэлтэй уяалдуулан “ Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахимм гэрчилгээ”-(RFID tag)-г тээврийн хэрэгслийд олгох арга хэмжээг хамтран зохион байгуулах</p>	Д.Батхүү - Аймгийн Цагдаагийн Газрын дарга
4	Орон нутгийн өмчийн газар	<p>1. Төрийн байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг тооллого бүртгэлд хамруулах</p> <p>2. Төрийн өмчийн хорооны шийдвэрээр шилжилт хөдөлгөөн болон хасалт хийгдээгүйгээс болж өр үүсгэж бүртгэл дээрээ байгаа тээврийн хэрэгслүүдийн баримт бичгийг бүрдүүлж бүртгэлээс хасуулах, шилжүүлэх үүсэн өр төлбөрийг барагдуулах:</p> <p>3. Төсөвт байгууллагуудын тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг шинэчлэн, ОНӨГ-ын бүртгэлийг АТТ-ийн бүртгэлтэй тулгаж, зөрүүг арилгах, татварын өртэй бол бүрэн төлж барагдуулах</p> <p>4. Аймгийн хэмжээний нэгдсэн бүртгэлтэй уяалдуулан “ Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахимм гэрчилгээ”-(RFID tag)-г тээврийн хэрэгслийд олгох арга хэмжээг хамтран зохион байгуулах</p>	Г.Лхагвахатан - Орон нутгийн өмчийн газрын дарга